



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 241

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар оролцогч ирээгүй 26,290,000.00 (хорин зургаан сая хоёр зуун ерэн мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, Сэлэнгэ аймгийн Гаалийн газрын дарга М.Дамдинхорол нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2022 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн
11/ дугаар тогтоолын хавсралт



Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Гаалийн
газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Хьюндай Старекс, 62-35 СЭҮ, арал:KMJWWH7HP6U717197	2006/ 2006	354,0	26,290,000.00	2,500,000.00
	Нийт дүн			26,290,000.00 (хорин зургаан сая хоёр зуун ерэн мянган)	2,500,000.00 (хоёр сая таван зуун)